

2025 ОНЫ 05 ДУГААР САРЫН 12-НЫ ӨДРИЙН
ШУУРХАЙ ЗӨВЛӨГӨӨНД НИЙСЛЭЛ, ДҮҮРГИЙН УДИРДАХ
АЖИЛТНААС ӨГСӨН ҮҮРЭГ ДААЛГАВАР

2025-05-12

Өндөртолгой

Үүргийн биелэлтийг Arial-11 фонтоор бичиж, **2025 оны 05 дугаар сарын 20-ны “Мягмар” гаралт** Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн Тогтоол шийдвэрийн биелэлт хариуцсан мэргэжилтэн (ERP Б.Одбаяр)-д албан бичгээр болон word файлаар ирүүлнэ үү.

Нийслэл, дүүргийн удирдлагаас цаг үеийн холбогдолтой өгөгдсөн үүрэг даалгаврын хэрэгжилтэд онцгой анхаарч биелэлтийг ирүүлэхдээ нийслэлийн Засаг даргын 2022 оны А/1106 дугаар захирамжаар батлагдсан “Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудын үйл ажиллагаанд хяналт шинжилгээ, үнэлгээ хийх, мэдээллийн нэгдсэн сан бүрдүүлэх журам”-ын 8.6 дахь хэсэгт заасан дараах шаардлагын дагуу тайлагнахыг анхаарна уу

8.6.Байгууллагаас ирүүлэх бодлогын баримт бичиг, хууль тогтоомж, тогтоол, шийдвэрийн хэрэгжилт, холбогдох тайлан, мэдээ нь дараах шаардлагыг хангасан байна:

8.6.1. үйл ажиллагааны гүйцэтгэлийг бүрэн багтаасан, тайлант хугацааг бүрэн хамруулсан байх.

8.6.2. үг үсгийн болон хэл найруулгын хувьд алдаагүй, тоо баримт зөрөөгүй байх;

8.6.5. тайлан дахь хүрсэн түвшний талаарх мэдээллийн үнэн, зөв эсэхийг нягтлан шалгасан байх;

8.6.6. хийсэн ажлыг бүрэн хамруулж, үйл ажиллагааны үр дүн, гүйцэтгэлд сөргөөр нөлөөлж буй хүчин зүйлийн үндэслэл, шалтгааныг тодорхой гаргасан байх;

8.6.7. хэрэгжилтийг 2000 (хоёр мянган) тэмдэгтэд багтааж, үр дүн, үр нөлөөг тайлагнах;

№	Өгсөн үүрэг даалгавар	Хариуцах эзэн
НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГАААС ӨГСӨН ҮҮРЭГ ДААЛГАВАР		
1	Нийслэлийн газрын маргаан таслан шийдвэрлэх комиссын ажлыг эрчимжүүлж, дүүргийн Засаг даргын Тамгын газар болон харьяа байгууллагууд шаардлагатай мэдээллийг шуурхай гаргаж, мэдээллээр хангах чиглэл өгөгдсөний дагуу дүүргийн нутаг дэвсгэр дэх газрын маргааны судалгааг гаргаж, холбогдох мэдээллийг хүргүүлж ажиллах.	ГЗБА
2	Дүүргийн хэмжээнд мод тарих ажлыг зохион байгуулан, олон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгслээр сурталчлан таниулж, ногоон байгууламжийн нэмэгдүүлэлт, зүлэгжүүлэлт, арчилгаа, усалгаанд анхаарах.	Гэрэлтүүлэг, ногоон байгууламж ОНӨААТҮГ, Нийт байгууллага
ДҮҮРГИЙН ЗАСАГ ДАРГЫН ОРЛОГЧООС ӨГСӨН ҮҮРЭГ ДААЛГАВАР		
3	2025 оны 05 дугаар сарын 27-ны өдөр төмөр замын “Хангай” зөрлөгт зохион байгуулагдах “Өдөрлөг”-ийн арга хэмжээний бэлтгэлийг сайтар хангаж, шугам замын иргэд, ойролцоох малчин өрхүүдэд төрийн үйлчилгээг хүргэх ажлыг зохион байгуулахад идэвхтэй оролцох.	ТЗУХ, Холбогдох байгууллагууд
4	Нийтийн эзэмшлийн гудамж, зам талбайн гэрэлтүүлгийн асалтыг 100 хувьд хүргэн, эвдрэл гэмтлийг шуурхай засварлан ажиллах.	Гэрэлтүүлэг, ногоон байгууламж ОНӨААТҮГ
5	“Олон Улсын Хүүхдийн Эрхийг хамгаалах өдөр”-ийн хүрээнд зохион байгуулагдах арга хэмжээний бэлтгэлийг сайтар ханган, тухайн өдөр зохион байгуулагдах ажил, арга хэмжээний төлөвлөгөөнд	НХХ, Нийт байгууллагууд

	тусгах саналаа (Нийгмийн хөгжлийн хэлтэст) хүргүүлэх.	
6	“Түншлэл-Үйлчилгээний соёлыг дээшлүүлэх жил-2025” зорилтот жилийн хүрээнд аж ахуйн нэгж, байгууллагууд ажилтан, албан хаагчиддаа харилцааны соёлыг төлөвшүүлэхэд чиглэсэн сургалт, сурталчилгаа, нөлөөллийн ажлуудыг зохион байгуулах.	Нийт байгууллагууд
7	Иргэд, оршин суугчдын зүгээс санал хүсэлт ихээр ирүүлж байгаатай холбогдуулан 2 дугаар хорооны нутаг дэвсгэр дэх Авто замын засвар, шинэчлэлтийн ажлын гүйцэтгэгч ХХК-тай холбогдон удаашралтай байгаа шалтгаан нөхцөлийг тодруулах, ажлын гүйцэтгэлийг хурдасгах талаар зохион байгуулалтын арга хэмжээг авч хэрэгжүүлэх.	Дүүргийн менежер Г.Дагвадорж, ТХҮХ, Гүйцэтгэгч ХХК
8	“Эрүүл орчин-Иргэдийн сайн сайхан” хөтөлбөрийн төлөвлөгөөний хэрэгжилтийг хангах хүрээнд ААНБ-ууд ажилтан, албан хаагчдаа гэмт хэрэг, зөрчил болон буруу зуршлаас урьдчилан сэргийлэх чиглэлээр тодорхой ажил, арга хэмжээг зохион байгуулах.	НХХ, Нийт байгууллагууд

ТАНИЛЦСАН
ЗАСАГ ДАРГЫН
ОРЛОГЧ

Х.ЦОГЦЭЦЭГ

ХЯНАСАН
ТӨРИЙН ЗАХИРГААНЫ УДИРДЛАГЫН ХЭЛТСИЙН
ДАРГА

Б.ОТГОНЖАРГАЛ

БОЛОВСРУУЛСАН
ТОГТООЛ ШИЙДВЭРИЙН БИЕЛЭЛТ ХАРИУЦСАН
МЭРГЭЖИЛТЭН

Б.ОДБАЯР